



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠳᠤ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны ᠐᠒ сарын 18 өдөр

Дугаар 1/᠒3

Алтай хот

Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын "Шар түвшин"-д шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн онцгой комиссын 2022 оны 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор улсын хэмжээнд коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг "Шар түвшин"-д 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн шилжүүлж, гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-ийг цуцалсантай холбогдуулан орон нутгийн хэмжээнд "Шар түвшин"-д шилжүүлж, гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-ийг цуцалсугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг хариу арга хэмжээ, тандалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, аймгийн "Нэгдсэн шуурхай штаб"-ын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, мэдээ тайланг тогтмол гаргах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Л.Баянбаатар), Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд онцгой комиссын орлогч, Нэгдсэн шуурхай штабын дарга (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР